

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 7

1. *Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал*

5 – 7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 23-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: С.Зулпхар, Л.Мөнхбаатар;*

*Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ж.Баярмаа, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Н.Учрал, Г.Уянгахишиг;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Э.Одбаяр, Ө.Шижир.*

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баясах нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг танилцуулав.

**Ц.Сандаг-Очир:** 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 3 гишүүн 2025 оны 12 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 4

Бүгд: 18

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхдагч хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхдагч хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 4

Бүгд: 18

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхдагч хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 07 минут үргэлжилж, 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
10 цаг 10 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Сандаг-Очир:** Ирц бүрдсэн байна. Ирцдээ орсон гишүүдээ дуудаарай, ажлын алба.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Бадарчийн Хэрлэн, Одонгийн Цогтгэрэл, Лувцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нарын 17 гишүүн ирж хуралдааны ирц 53.1 хувьтай байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлдсэн үү? Санал хураалт.

1. Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 3 гишүүн 2025 оны 12 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

2. Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхдагч хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

3. Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхдагч хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

4. Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

5. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

---

6. Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл анхдагч хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

7. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганы хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 07 минут үргэлжилж, 10 цаг 17 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**